



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 1/518

Мандалговь

Эрх шилжүүлэн ажил
гүйцэтгүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр аймгийн ИТХ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 25 ны өдрийн 15 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын 3.1-д батлагдсан "Зүүн бүсийн сум дундын Эрүүл мэндийн төвийн ажилчдын байрны их засвар"-ын ажлын эрхийг Говь-Угтаал сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

Хоёр. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, шууд гэрээ байгуулан, ажлыг чанартай гүйцэтгүүлж, үе шатны ажилд тавьж, холбогдох бичиг баримтыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг Говь-Угтаал сумын Засаг дарга /Б.Доржсүмбэр/-д үүрэг болгосугай.

Гурав. Худалдан авах ажиллагааны болон гүйцэтгэлийн бичиг баримтын бүрдлийг хянаж, журмын дагуу санхүүжилт хийхийг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Санхүү төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0300879